



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/020/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3-4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.2.25 № 186
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.САРАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар 88.2 хувиар үнэлж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2126050061

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,168,300.00	6,459,640.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,168,300.00	6,459,640.00
354	Хангамжийн материал	3,168,300.00	6,459,640.00
35410	Бичиг хэргийн материал	1,960,300.00	3,102,100.00
35420	Аж ахуйн материал	1,208,000.00	3,357,540.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,687,996.24	49,179,225.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,687,996.24	49,179,225.57
392	Биет хөрөнгө	45,237,996.24	48,029,225.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,564,142.00	51,713,142.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,047,590.86)	(27,171,105.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,380,090.00	30,755,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,658,644.90)	(7,268,600.50)
393	Биет бус хөрөнгө	1,450,000.00	1,150,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(350,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	49,856,296.24	55,638,865.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,856,296.24	55,638,865.57
51	Засгийн газрын хувь оролцоо	49,856,296.24	55,638,865.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	33,630,236.85	33,630,236.85
51101	Өмч: - төрийн	33,630,236.85	33,630,236.85
512	Хуримтлагдсан үр дүн	16,226,059.39	22,008,628.72
51210	Өмнөх үеийн үр дүн	-	16,226,059.39
51220	Тайлант үеийн үр дүн	16,226,059.39	5,782,569.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	49,856,296.24	55,638,865.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	280,930,950.00	374,772,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,521,250.00	12,040,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,521,250.00	12,040,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,765,000.00	12,040,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,765,000.00	12,040,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,756,250.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	253,409,700.00	362,732,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,409,700.00	362,732,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,409,700.00	362,732,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	264,704,890.61	368,989,830.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,704,890.61	368,989,830.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,585,550.71	345,416,636.02

**Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,786,281.76	274,579,902.35
210101	Үндсэн цалин	94,036,281.76	117,933,918.83
210102	Нэмэгдэл	67,400,000.00	125,597,797.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,350,000.00	19,380,000.00
210104	Урамшуулал	12,000,000.00	11,668,186.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,475,200.00	36,299,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15,283,200.00	24,683,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,798,000.00	2,904,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,438,400.00	1,452,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,600.00	1,452,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,596,000.00	5,807,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,945,578.34	8,771,710.00
210401	Бичиг хэрэг	4,545,770.00	3,626,325.00
210402	Тээвэр, шатахуун	2,900,000.00	2,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,172,998.34	918,525.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,326,810.00	1,526,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,735,853.00
210602	Тавилга	(67,000.00)	-
210604	Урсгал засвар	4,067,000.00	4,735,853.00
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	5,100,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	5,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,670,000.00	3,396,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,670,000.00	2,956,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,508,490.61	12,533,470.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,328,490.61	12,033,470.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,119,339.90	23,573,194.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,610,096.00	698,580.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,310,096.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	698,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,509,243.90	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,509,243.90	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	22,874,614.65
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,874,614.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,226,059.39	5,782,569.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,226,059.39	5,782,569.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	270,174,700.00	374,772,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,765,000.00	12,040,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,765,000.00	12,040,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,765,000.00	12,040,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,765,000.00	12,040,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	253,409,700.00	362,732,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,409,700.00	362,732,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,409,700.00	362,732,400.00

Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	260,049,700.00	360,247,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260,049,700.00	360,247,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,930,360.10	336,674,505.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,786,281.76	274,579,902.35
210101	Үндсэн цалин	94,036,281.76	117,933,918.83
210102	Нэмэгдэл	67,400,000.00	125,597,797.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,350,000.00	19,380,000.00
210104	Урамшуулал	12,000,000.00	11,668,186.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,475,200.00	36,299,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15,283,200.00	24,683,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,798,000.00	2,904,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,438,400.00	1,452,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,600.00	1,452,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,596,000.00	5,807,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,010,878.34	9,245,800.00
210401	Бичиг хэрэг	5,799,070.00	3,826,325.00
210402	Тээвэр, шатахуун	2,900,000.00	2,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,714,998.34	918,525.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,596,810.00	1,800,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,108,000.00	6,053,103.00
210602	Тавилга	(67,000.00)	-
210604	Урсгал засвар	4,175,000.00	6,053,103.00
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	5,100,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	5,100,000.00
2108	хураамж	5,170,000.00	4,896,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,670,000.00	4,456,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,119,339.90	23,573,194.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,610,096.00	698,580.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,310,096.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	698,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,509,243.90	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,509,243.90	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	22,874,614.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,874,614.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,125,000.00	14,524,700.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,125,000.00	14,524,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,125,000.00	14,524,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,125,000.00	14,524,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,125,000.00	14,524,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,125,000.00)	(14,524,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	33,630,236.85	0.00	0.00	33,630,236.85
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	16,226,059.39	16,226,059.39
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,630,236.85	0.00	16,226,059.39	49,856,296.24
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	33,630,236.85	0.00	16,226,059.39	49,856,296.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,630,236.85	0.00	16,226,059.39	49,856,296.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	5,782,569.33	5,782,569.33
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,630,236.85	0.00	22,008,628.72	55,638,865.57

Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,411,300.00	351,897,785.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,411,300.00	351,897,785.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,411,300.00	351,199,205.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,395,400.00	274,579,902.35
210101	Үндсэн цалин	119,520,000.00	117,933,918.83
210102	Нэмэгдэл	130,426,800.00	125,597,797.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,480,000.00	19,380,000.00
210104	Урамшуулал	21,968,600.00	11,668,186.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,299,400.00	36,299,400.00
210201	Тэтгэврийн даатгал	24,683,600.00	24,683,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,904,000.00	2,904,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,452,000.00	1,452,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,452,000.00	1,452,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,807,800.00	5,807,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,260,000.00	9,245,800.00
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	3,826,325.00
210402	Тээвэр, шатахуун	3,100,000.00	2,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	918,525.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,160,000.00	1,800,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,900,000.00	11,849,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,900,000.00	4,849,000.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,200,000.00	5,100,000.00
210702	Дотоод албан томилолт	5,200,000.00	5,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,856,500.00	13,625,103.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,978,100.00	13,185,103.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878,400.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	698,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	698,580.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	698,580.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
620003	Үйлчлэх ажилтан	-	-
620004	Гэрээт ажилтан	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21.6 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 21.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 0.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 21,624.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь материаллаг байдлын түвшнээс 17,934.3 мянган төгрөгөөр их байгаа боловч завсрын аудитаар өгсөн 19,058.2 мянган төгрөгийн аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Аудитаар илэрсэн 1 зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлаас 1,123.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих мэдээллээс 7.7 хувь буюу 1 мэдээллийн хугацааг хоцроосон, хөрөнгө зарцуулсантай холбоотой тушаал, шийдвэр гэх мэт 6 мэдээллийг огт оруулаагүй байна.

Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулах

2. Ажил үүргийн давхардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт Нягтлан бодогчийн ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод нярвыг хавсран гүйцэтгэхээр тусгасан байна. Нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна.

Өгсөн зөвлөмж Санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангах.

3.2 Албан шаардлага

1. Ажил гүйцэтгэх гэрээ дүгнэхтэй холбоотой асуудал

Ажил гүйцэтгэх гэрээ дүгнэсэн актгүй байгаа нь Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1-т "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.", 351 дүгээр зүйлийн 351.1.2-т "гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Ажил гүйцэтгэл гэрээ"-ний 3.5 дахь заалттай нийцэхгүй байна.

2. Бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Бараа материалын тооллогын бүртгэл хийгдээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" гэж заасантай нийцэхгүй байна.

3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ гаргасантай холбоотой асуудал

Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Анхан шатны нотлох баримтаар баталгаажуулаагүй 2 сарын хугацаатай цалинтай чөлөө олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална.” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны нотлох баримтаар баталгаажуулаагүй 2 сарын хугацаатай цалинтай чөлөө олгосон байна.	1	2,566.0			1	2,566.0			
2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Ажил гүйцэтгэл гэрээ"-нд Ажил гүйцэтгэх гэрээ дүгнэсэн актгүй.	1	13,000.0			1	13,000.0			
Бараа материалын тооллогын бүртгэл хийгдээгүй.	1	5,709.6			1	5,709.6			
Нягтлан бодогчийн ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод нярвыг хавсран гүйцэтгэхээр тусгасан байна. Нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна.	1	-					1	-	
Дүн	4	21,275.6			3	21,275.6	1	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих мэдээллээс 7.7 хувь буюу 1 мэдээллийн хугацааг хоцроосон, 6 мэдээллийг огт оруулаагүй байна. (хөрөнгө зарцуулсантай холбоотой тушаал, шийдвэр гэх мэт)	1	348.6						1	348.6
Дүн	1	348.6						1	348.6